

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН
САЙДЫН ТУШААЛ**

Журам шинэчлэн батлах тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1.“Аж ахуйн нэгж, байгууллага цахим системд нэвтрэх, санхүүгийн тайлан илгээх, харилцагч санхүүгийн байгууллага тайланг хянаж, хүлээн авах, тайлангийн нэгтгэл хийх журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Б.Болормаа/-т даалгасугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Журам шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 2020 оны 46 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА ЦАХИМ СИСТЕМД НЭВТРЭХ, САНХҮҮГИЙН ТАЙЛАН ИЛГЭЭХ, ХАРИЛЦАГЧ САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ ХЯНАЖ, ХҮЛЭЭН АВАХ,ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ ХИЙХ ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангийн И-Баланс цахим систем (цаашид “цахим систем” гэх)-д нэвтрэх, санхүүгийн тайлан илгээх, харилцагч санхүүгийн байгууллага санхүүгийн тайланг хянаж, хүлээн авах, мэдээллийн сан бүрдүүлэх, тайлангийн нэгтгэл хийх, цахим архив үүсгэх, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд энэ журмыг мөрдөнө.

1.2.Цахим системд Улсын бүртгэлийн ерөнхий газрын (ХУР) болон И-Такс системд бүртгэгдсэн аж ахуйн нэгж, байгууллага, төлөөний газар, улс төрийн нам, сууц өмчлөгчдийн холбоо, үйлдвэрчний эвлэлийн холбоо, үйлдвэрчний эвлэлийн хороо, өрхийн эрүүл мэндийн төв, мэргэжлийн холбоо, мэргэжлийн нэгдсэн холбоо (цаашид “аж ахуйн нэгж, байгууллага”)-г хамруулна.

ХОЁР.АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА ЦАХИМ СИСТЕМД НЭВТРЭХ, ТАЙЛАН ИЛГЭЭХ

2.1.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар “Нэвтрэлтийн нэгдсэн систем”-д бүртгэлтэй эрхээр цахим системд нэвтэрнэ.

2.2.Улсын бүртгэлийн ерөнхий газрын (ХУР) системд бүртгэлгүй аж ахуйн нэгж, байгууллага нь И-Такс системийн ерөнхий эрхээр цахим системд нэвтэрнэ.

2.3.Аж ахуйн нэгж, байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайланг харилцагч санхүүгийн байгууллагад цахим системээр илгээнэ.

2.4.Цахим системд илгээсэн санхүүгийн тайлангийн мэдээллийн үнэн зөв байдлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хариуцах бөгөөд дараах шаардлагыг хангасан тайлан байна. Үүнд:

2.4.1.аж ахуйн нэгж, байгууллага нь өмчийн төрлөө зөв тодорхойлсон эсэхийг нягталсан байх;

2.4.2.илгээсэн санхүүгийн тайлан болон тодруулгууд бодитой, үнэн зөв илэрхийлэгдсэн байх болон тодруулгын тэмдэглэл, судалгаа зэргийг бүрэн гүйцэт бөглөсөн байх;

2.4.3.өмнөх хугацааны тайлантай уялдаатай байх;

2.4.4.өссөн дүнгээр тайлагнасан байх.

2.5.Аж ахуйн нэгж, байгууллага нь санхүүгийн тайланд залруулга хийж болох бөгөөд хамгийн сүүлд илгээсэн хугацаагаар тайлан илгээсэн хугацааг тодорхойлно.

2.6.Санхүүгийн тайлан илгээх эцсийн хугацаа ажлын бус өдөр, эсхүл нийтээр тэмдэглэх баярын өдөртэй давхацвал дараагийн ажлын өдөр уг хугацаа дуусна.

2.7.Цахим системд аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь үүсгэсэн, шивж буй, илгээсэн, шийдвэрлэж буй, буцаагдсан, цуцлагдсан, баталгаажсан төлөвүүдтэй байна. Тайлангийн хугацаа дуусаж систем хаагдсан үед санхүүгийн тайлан баталгаажсан, илгээсэн, шийдвэрлэж буй төлөвөөс бусад төлөвт байвал тайлан тушаагаагүйд тооцно.

2.8.Цахим системээс аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлан нь баталгаажсан тохиолдолд PDF хэлбэрээр татагдана.

ГУРАВ.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ ХЯНАХ, ХҮЛЭЭН АВАХ

3.1.Харилцагч санхүүгийн байгууллага “илгээсэн” төлөвт байгаа санхүүгийн тайланг “шийдвэрлэж буй” төлөвт шилжүүлэн хагас жилийн санхүүгийн тайланг 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн санхүүгийн тайланг 4 дүгээр сарын 10-ны өдрийн дотор тус тус хянаж, хүлээн авна.

3.2.Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг хянаж, хүлээн авах үүрэг бүхий албан тушаалтан (цаашид “мэргэжилтэн” гэх) нь цахим системд илгээсэн алдаатай санхүүгийн тайланг цахим системийн “Тайлангийн хүсэлтийн мэдээлэл” цонхны “Хүсэлт шийдвэрлэлт” хэсэгт алдааг залруулах талаар холбогдох тэмдэглэлийг оруулснаар санхүүгийн тайлан нь “буцаагдсан” төлөвт шилжинэ.

3.3.Аж ахуйн нэгж, байгууллага нь “буцаагдсан” төлөвтэй санхүүгийн тайланг ажлын 5 өдөрт багтаан харилцагч санхүүгийн байгууллагад алдааг засаж илгээнэ.

3.4.Аж ахуйн нэгж, байгууллага нь хугацаа хоцроосон тохиолдолд “Холбох хүсэлт”-ийг харилцагч санхүүгийн байгууллагад илгээнэ.

3.5.Төрийн болон орон нутгийн төрийн өмчит, тэдгээрийн оролцоотой, засгийн газартай бүтээгдэхүүн хуваах, тогтвортой байдлын болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан, тусгайлан мэдээлсэн аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайланг дараах шаардлагыг хангуулан хүлээн авна. Үүнд:

3.5.1.санхүүгийн тайланг цахим системд илгээсэн байх;

3.5.2.тойрох хуудас зурах холбогдох газар, хэлтсийн мэргэжилтэн нь тайлангийн мэдээллийг хянан үзэж гарын үсэг зурна. Аж ахуйн, нэгж байгууллагын ерөнхий нягтлан бодогч өөрийн биеэр тойрох хуудсыг харилцагч санхүүгийн байгууллагын мэргэжилтэнд хүлээлгэн өгөх;

3.5.3.харилцагч санхүүгийн байгууллагын мэргэжилтэн нь энэ журмын хавсралтаар батлагдсан тойрох хуудсыг хүлээн авч, цахим системд илгээсэн санхүүгийн тайланг хүлээн авна;

3.6.Харилцагч санхүүгийн байгууллага нь аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага эсхүл ерөнхий нягтлан бодогчийн цахим системд бүртгэлтэй цахим шуудан (и-мэйл хаяг)-гийн хаягаар санхүүгийн тайланг буцаасан тухай мэдэгдлийг хүргүүлнэ.

3.7.Харилцагч санхүүгийн байгууллага нь цахим шуудангаар мэдээлэл хүргүүлэх зардлыг тухайн жилийн улс, орон нутгийн төсөвт тусгуулсан байна.

ДӨРӨВ.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ЗАЛРУУЛГА ХИЙХ

4.1.Цахим системд “буцаагдсан” төлөвт шилжсэн санхүүгийн тайланг цахим шуудан (и-мэйл хаяг)-аар мэдэгдэл очсон өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор аж ахуйн нэгж, байгууллага нь “Тайлангийн хүсэлтийн мэдээлэл” цонхны “Хүсэлтийн түүх” хэсэг дэх тайлбарын дагуу алдааг засаж харилцагч санхүүгийн байгууллагад илгээнэ.

4.2.“Баталгаажсан” төлөвтэй санхүүгийн тайланг аж ахуйн нэгж, байгууллага нь нэг удаа залруулга хийж болно.

4.3.“Баталгаажсан” төлөвтэй санхүүгийн тайланд залруулга хийн баталгаажих эцсийн хугацаа тухайн оны 12 дугаар сарын 10-ны өдрөөр дуусгавар болно.

4.4.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан үндэслэлээр эсхүл аж ахуйн нэгж, байгууллагын засварын хүсэлтийн эрх дууссан бол цахим системд дараах нөхцөлийг хангасан тохиолдолд санхүүгийн тайланд залруулга хийнэ. Үүнд:

4.4.1.аудитын компани нь цахим системд аудитын дүгнэлтийг оруулсан байх;

4.4.2.цахим системд аж ахуйн нэгж, байгууллага нь залруулах хүсэлтээ илгээсэн байх;

4.4.3.мэргэжилтэн залруулах хүсэлтийг хүлээн авч санхүүгийн тайланг “шивж буй” төлөвт шилжүүлсэн байх;

4.4.4.цахим системд аж ахуйн нэгж, байгууллага нь аудитын дүгнэлтэд үндэслэн санхүүгийн тайланд залруулга хийж, илгээсэн байна.

4.5.Мэргэжилтэн нь аж ахуйн нэгж, байгууллагын залруулсан санхүүгийн тайланг цахим системд “илгээсэн” өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор хянан, шийдвэрлэнэ.

4.6.Аж ахуйн нэгж, байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өөрчлөгдсөн бол албан хүсэлт, хувьцаа эзэмшигчийн тогтоолыг файлаар хавсарган завсрын үеийн санхүүгийн тайланг цахим системд илгээнэ.

4.7.Аж ахуйн нэгж, байгууллагыг нийлүүлсэн, нэгтгэсэн, хуваасан, тусгаарласан, татан буулгасан бол албан хүсэлт, хувьцаа эзэмшигчийн тогтоол, аудитын дүгнэлт зэргийг файлаар хавсарган завсрын үеийн санхүүгийн тайланг цахим системд илгээнэ.

4.8.Цахим системд “илгээсэн” төлөвтэй завсрын үеийн санхүүгийн тайлан нь алдаатай, болон бүрдүүлэлтийн материал дутуу бол мэргэжилтэн цахим системийн “Тайлангийн хүсэлтийн мэдээлэл” цонхны “Хүсэлт шийдвэрлэлт” хэсэгт холбогдох тэмдэглэлийг оруулснаар завсрын үеийн санхүүгийн тайлан нь “буцаагдсан” төлөвт шилжинэ.

4.9.Цахим системд “буцаагдсан” төлөвт шилжсэн завсрын үеийн санхүүгийн тайланг цахим шуудан (и-мэйл хаяг)-аар мэдэгдэл очсон өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор аж ахуйн нэгж, байгууллага нь “Тайлангийн хүсэлтийн мэдээлэл” цонхны “Хүсэлтийн түүх” хэсэг дэх тайлбарын дагуу алдааг засаж харилцагч санхүүгийн байгууллагад илгээнэ.

4.10.Мэргэжилтэн нь журмын 4.6, 4.7, 4.9-д заасан завсрын үеийн санхүүгийн тайланг цахим системд “илгээсэн” өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор “шийдвэрлэж буй” төлөвт оруулан хянан, шийдвэрлэнэ. Хэрэв алдаатай бол “Хүсэлтийн түүх” хэсэгт тэмдэглэл үйлдэн буцаана.

4.11.Зөрчлийн тухай хуулийн 11.18 дугаар зүйлийг зөрчсөн, шинээр үүсгэн байгуулагдсан, системийн алдаанаас болж эхний үлдэгдэл нь буруу татагдсан, санхүүгийн тайлангийн маягт нь шинэчлэгдсэн, өмчийн төрөл өөрчлөгдсөн аж ахуй нэгж, байгууллага нь “нээлтийн тайлан” гаргана.

4.12.Аж ахуй нэгж, байгууллагыг татан буулгах шийдвэр гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор “Хаалтын тайлан”-г харилцагч санхүүгийн байгууллагад цахим системд илгээнэ.

4.13.Аудитын компани нь аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулсан тохиолдолд гэрээний дугаар, гэрээ байгуулсан он, сар, өдөр, хүчинтэй хугацааг цахим системд оруулсан байна. Аудитын дүгнэлт гарсан бол дүгнэлтийг цахим системд файл хэлбэрээр хавсарган оруулна.

4.14.Ажлын ачааллыг харгалзан тайлан хүлээн авах үед нэг мэргэжилтэнд 1000 аж ахуйн нэгж ногдохоор тооцож, хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогчийг түр ажиллуулж болох бөгөөд тайлан хүлээн авах, бусад хариуцлагыг үндсэн орон тооны мэргэжилтэн хариуцна. Үндсэн орон тооны мэргэжилтэн нь гэрээт ажилтныг мэдээлэл арга зүйгээр ханган ажиллана.

ТАВ.ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ, АШИГЛАХ, СИСТЕМ ДЭХ АДМИНЫ ЭРХ, ҮҮРЭГ

5.1.Цахим мэдээллийн сан бүрдүүлэх үйл явцыг цахим системд “Админ” хэрэгжүүлнэ.

5.2.“Админ” нь цахим системд алдаа засварлуулах, өмчийн төрөл солих, хөгжүүлэлт болон сайжруулалтын саналыг Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв улсын үйлдвэрийн газар (цаашид “ГТСМТТ” гэх)-ийн “Тикет” систем рүү тухай бүрд хүргүүлэх ажлыг зохион байгуулна. Тус систем рүү хүсэлтийг дараах алхмаар илгээнэ.Үүнд:

5.2.1.харилцагч санхүүгийн байгууллагын мэргэжилтнээс ирүүлсэн хүсэлтийг “Админ” хянан шалгасны үндсэн дээр “Тикет” системд хүсэлтийг үүсгэнэ;

5.2.2.“ГТСМТТ” нь “Админ”-ний “Тикет” системээр ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэнэ.

5.3.Цахим системд санхүүгийн тайлан харах эрх (цаашид “тайлан харах эрх” гэх)-ийг журмын 5.6.1, 5.6.2, 5.6.3-д заасан этгээдэд олгоно.

5.4.Цахим системийн мэдээллийн санд үүссэн аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн мэдээллийг систем хооронд мэдээлэл солилцох хэлбэрээр олгоно.

5.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн мэдээллийн технологийн хэлтэс (цаашид “СМТХ” гэх)-т журмын 5.6-д заасан этгээд цахим мэдээллийн сангаас систем хооронд мэдээлэл солилцох хүсэлтээ албан бичгээр холбогдох баримтын хамт ирүүлнэ.

5.6.Байгууллага нь албан бичигт тайлан харах шаардлага болон хугацааг тусгасан байна. “Тайлан харах эрх”-ийг дараах байгууллагад олгоно. Үүнд:

5.6.1.Төрийн байгууллага;

5.6.2.Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага;

5.6.3.Бусад хууль тогтоомжид заасан этгээд.

5.7.“Тайлан харах эрх”-ийг “Админ” нь дараах хугацаагаар олгоно. Үүнд:

5.7.1.журмын 5.6.1-д заасан байгууллагад хугацаагүй;

5.7.2.журмын 5.6.2 болон 5.6.3-т заасан байгууллагуудад албан бичигт дурдсан хугацаагаар.

5.8.Цахим системд “Админ” нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

5.8.1.тайлант үеүдэд цахим системийг нээж, хаах;

5.8.2.аж ахуйн нэгж, байгууллагын харьяалал шилжилт хөдөлгөөнийг хийх;

5.8.3.аж ахуйн нэгж, байгууллагын харьяаллыг “И-Такс” системээс жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор татах;

5.8.4.цахим системд “хуулийн этгээд” цонхны “байгууллагын төлөв” хэсэгт аж ахуйн нэгж, байгууллагын идэвхтэй болон идэвхгүй төлөвийг солих;

5.8.5.цахим системд санхүүгийн тайлангийн сунгах хугацааг оруулах;

5.8.6.цахим системд санхүүгийн тайлан, тодруулгын маягтын зураглал болон дансны жагсаалтыг тестийн орчинд боловсруулж, бодит горимд нэвтрүүлэх;

5.8.10.цахим системд санхүүгийн “тайлан харах” эрхийг бүртгэлжүүлэх.

5.9.“СМТХ” нь журмын 5.6-д заасан этгээдтэй гэрээ байгуулан, санхүүгийн тайлангийн холбогдох мэдээллийг тухайн байгууллагад сервисээр дамжуулна.

ЗУРГАА.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

6.1.Санхүүгийн тайлангаа тайлагнах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагыг “идэвхтэй” төлөвт тооцно.

6.2.“Идэвхгүй” төлөвт сүүлийн 2 жил санхүүгийн тайлангаа ирүүлээгүй аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулна.

6.3.Цахим системд “илгээсэн” төлөвтэй аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгтгэл, дүн шинжилгээг 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хийнэ.

6.4.Харилцагч санхүүгийн байгууллага нь өөрийн харьяаллын аж ахуйн нэгж, байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланг нэгтгэн, дүн шинжилгээ хийж болно.

6.5.Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тайланг улсын хэмжээнд нэгтгэн, санхүүгийн тайлангийн шинжилгээний хамт удирдлагад танилцуулна.

ДОЛОО.ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

7.1.Санхүүгийн тайлангийн И-Баланс цахим системийн агуулга, бүтэц, хөгжүүлэлт нь мэдээллийн аюулгүй байдлын ISO 27001:2013 стандартын шаардлагыг хангасан байна. Үүнд:

7.1.1.цахим системд аж ахуйн нэгж байгууллагаас хандсан хандалт болон үйлдэл бүр нь “хүсэлтийн түүх” хэсэгт харагдах бөгөөд он тус бүрээр архивлагдана;

7.1.2.цахим системд санхүүгийн тайлангийн нүүр хэсэгт харилцагч санхүүгийн байгууллагын мэргэжилтэн хэзээ санхүүгийн тайланг хүлээн авсан мэдээлэл байна, QR код нь зөвхөн тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нэвтрэх эрхтэй этгээдэд хамааралтай байна;

7.1.3.цахим системд “баталгаажсан” төлөвтэй санхүүгийн тайланг хэвлэх боломжтой байх;

7.1.4.системийн ачааллын тестийг хагас жил болон жилийн эцсийн тайлан илгээлтээс өмнө хийж ачааллыг тэнцвэржүүлэх.

НАЙМ.”ГААЛЬ, ТАТВАР САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВ” УЛСЫН ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЧИГ ҮҮРЭГ

8.1.Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар (цаашид “НБББГ” гэх), “ГТСМТТ”-тэй жилийн төлөвлөгөөг боловсруулан, тухайн оны 1 дүгээр сард батална.

8.2.“ГТСМТТ” нь цахим системийн хэвийн тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллана.

8.3.“НБББГ”-аас ирүүлсэн цахим системийн алдаа, нэмэлт хөгжүүлэлтийг тухай бүрд шийдвэрлэнэ.

8.4.“ГТСМТТ” нь цахим системийн санхүүгийн тайлангийн мэдээллийг солилцоход “СМТХ”-ээр дамжуулан олгоно.

8.5.“ГТСМТТ” нь цахим системээс журмын 5.6-д заасан этгээдэд дундын сервисээр дамжуулж буй /ТЕГ, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Үндэсний статистикийн газар гэх мэт гэрээ байгуулсан газрууд/ мэдээллийн аюулгүй байдал болон гэрээний заалтын дагуу мэдээлэл дамжуулах үйл явцыг хариуцна.

8.6.Цахим системтэй холбоотой аж ахуйн нэгж, байгууллага болон иргэнээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэнэ.

ЕС.БУСАД

9.1.Журамд заасан хугацаанд санхүүгийн тайланг цахим системд илгээгээгүй аж ахуйн нэгж, байгууллагад Нягтлан бодох бүртгэлийн тухай, Аудитын тухай, Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэн тухайн тайлант үеийн санхүүгийн тайланг хүлээн авна.

9.2.Аж ахуйн нэгж, байгууллага нь журмын 9.1 дэх заалтын дагуу хариуцлага тооцуулсан нь /тооцсон/ өмнөх тайлант үеийн санхүүгийн тайланг нь харилцагч санхүүгийн байгууллага хүлээн авах үндэслэл болохгүй.

9.3.Журмыг зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд холбогдох хууль, журмын дагуу харилцагч санхүүгийн байгууллага хариуцлага тооцно.

----oOo---